

БАТЛАВ
ХӨВСГӨЛ АЙМГИЙН БОЛОВСРОЛЫН
ГАЗРЫН ДАРГА О.БАДРАА

2024 оны 08 дугаар сарын 28-ны өдөр

ХӨВСГӨЛ АЙМГИЙН СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН
БАЙГУУЛЛАГЫН **2024-2025 ОНЫ ХИЧЭЭЛИЙН ЖИЛИЙН ЗОРИЛГО, ЗОРИЛТ**

ЗОРИЛГО:
“ГҮЙЦЭТГЭЛ ТӨВТЭЙ ТӨЛӨВЛӨЛТӨД” СУУРИЛСАН БОЛОВСРОЛЫН
ҮЙЛЧИЛГЭЭГ ХҮҮХЭД БҮРД ХҮРГЭНЭ.

ЕРӨНХИЙ ЧИГЛЭЛ	ЗОРИЛТ
БАЙГУУЛЛАГЫН МЕНЕЖМЕНТ	1. Сургууль, цэцэрлэгийн бие даасан байдлыг дэмжиж, гүйцэтгэл төвтэй төлөвлөлтөөр боловсролын үйлчилгээний үр дүнг сайжруулж, ялгааг арилгах; ачааллыг тэнцвэржүүлэх. 2. “Судалгаа үнэлгээ - 2025”-ыг зохион байгуулж Хөвсгөл аймгийн боловсролын хөгжлийн “ОЮУНЛАГ ХӨВСГӨЛ-2” хөтөлбөрийг боловсруулах;
БАГШ, СУРАЛЦАХУЙН ХӨГЖИЛ	3. Хичээл сургалтын үйл ажиллагааг мэргэжлийн багш нарын бүлэг, хамтын ажиллагаанд тулгуурлан сайжруулж, суралцагчийн ялгаатай хэрэгцээнд нийцүүлэн хичээлийн бэлтгэлийг чанартай бэлтгэн үр дүнтэй хэрэгжүүлэх; 4. Багшийн онол арга зүйн чадамжийг дээшлүүлэх, цахим сангаас суралцах, бие даан хөгжих боломжийг хүртээмжтэй болгох насан туршийн суралцахуйн бодлого боловсруулж хэрэгжүүлэх; 5. Багшийн арга зүй, даалгаврын бүтээлч технологийг хөгжүүлэх замаар суралцагчдын суралцах чадвар, чанарт ахиц гаргах;
СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТ	6. Цахим технологид суурилсан сургалтын болон суралцахуйг дэмжсэн платформын ашиглалтыг нэмэгдүүлэх; 7. Сургуулийн өмнөх, бага, дунд, дээд боловсролын залгамж холбоог мэргэжлийн хөгжлийн бүлгийн үйл ажиллагаагаар дамжуулан сайжруулах; 8. Сурагчийн бие бялдар, эрүүл мэнд, урлаг, англи хэлний боловсролыг дэмжин, чанарын ахиц гаргах; 9. Ялгаатай хэрэгцээтэй хүүхдийг боловсролын үйлчилгээнд тэгш хамруулж, тэдний онцлог, хэрэгцээнд суурилсан хөгжлийн дэмжлэгийг чанар, үр дүнтэй үзүүлэхэд хамтын оролцоог идэвхжүүлэх; 10. Сургалтын бүтээлч үйлийг идэвхжүүлэн, иннновац шинэ санаа шингэсэн сургалтын шилдэг бүтээлүүдийг түгээн дэлгэрүүлж, БОЛОВСРОЛ-ИННОВАЦЫН дэлгүүрээр худалдан борлуулж, багшид бодит орлого бий болгох; 11. Үнэлгээний арга хэлбэр, даалгаврын боловсруулалтыг олон улсын үнэлгээний чиг хандлага, хөтөлбөрийн хүрэх үр дүнд суурилсан зохион байгуулж, дүн шинжилгээ хийн, улс, аймгийн

	дунджаас доогуур үнэлэгдсэн сургалтын байгууллага, судлагдахуун, багштай ажиллах;
ХҮҮХДИЙН ХӨГЖИЛ, ХАМГААЛАЛ	12. “Сургууль, цэцэрлэгийн орчин дахь хүүхэд хамгаалал, эрүүл аюулгүй байдал-Нэгдүгээрт” арга хэмжээг зохион байгуулж үр дүнг тооцох; 13. Сургалын байгууллагын эмч, нийгмийн ажилтан, сэтгэл зүйч, анги удирдсан багш, байрын багшийн хамтын ажиллагааг сайжруулж, эцэг эх олон нийтийн оролцоо хандлагыг нэмэгдүүлэн, хүүхдийн хөгжил, хамгааллын цогц арга хэмжээг хэрэгжүүлэх, 14. Цэцэрлэг, сургууль бүр суралцагчдад “Өдөр бүр-Сүү” арга хэмжээг хэрэгжүүлж, хүүхдийн өсөлт, эрүүл мэндийг дэмжин ажиллах; 15. Дунд, ахлах ангийн суралцагч ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, мэргэжлээ зөв сонгоход дэмжлэг үзүүлэхэд чиглэсэн арга хэмжээг бэлтгэсэн мэргэжил сонголтын зөвлөхүүдэд түшиглэн хэрэгжүүлэх;
СУРГАЛТЫН ОРЧИН	16. Суралцахуйг дэмжсэн орчныг бүрдүүлж, сургууль бүр цахим шалгалтын танхим, цэцэрлэг бүр номын сан байгуулах; 17. Номын сан, дотуур байрыг суралцагчдын бие даан суралцах чадварыг дэмжих орчин болгон хөгжүүлэх 18. Хоол үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж, технологи, орчинг сайжруулж, шим тэжээлийг нэмэгдүүлэх;